

**СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН**

2024 оны 12 дугаар сарын 10-ны өдөр

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ /хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал/	Тасарсан болон удааширч буй шалтгаан
1	2	3	4	5	6
САЛБАР ЧИГЛЭЛ: 1					
<b>1. Засгийн газрын тогтоол</b>					
1.1.	<b>№438</b>	Журам батлах тухай <b>№438</b>  <b>2024-12-13</b> Даатгуулагч тэтгэмж авахад бүрдүүлэх	Нийгмийн даатгалын болон НДСОТТХуулийн дагуу ХЧТА-ны 3621, жирэмсэн амаржсаны 2998, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж 1384, ҮОМШӨ-ний ХЧТА-ны 45, ҮОМШӨ-ний нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж-6 ажилгүйдлийн 4122, нийт 12176 иргэний тэтгэмжийн материалыг хүлээн авч тогтоосон байна.	100%	

1.2.	<b>№215</b>	Цахим шилжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай  <b>2024-05-15</b>	Төрийн үйлчилгээг цахимаар үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх ажлын хүрээнд Нийгмийн даатгалын архивын үйлчилгээг иргэд даатгуулагчдад хөнгөн шуурхай үзүүлэх зорилгоор шимтгэл төлөлтийн лавлагааг бусад аймаг дүүргээс цахимаар авч эхэлсэн ба тайлант хугацаанд бусад аймаг дүүрэг рүү 547 хүсэлт илгээснээс 533 хариу ирсэн ба бусад аймаг дүүргээс 525 хүсэлтийг хүлээн авч 519 хариуг хүргүүлсэн байна.  Мөн албан байгууллага, иргэдээс ирж байгаа бичиг болон өргөдөл гомдлыг Edoc, Able, ERP, songinohairhan@ndaatgal.mn зэрэг цахим хаягаар хүлээн авч шийдвэрлэж байна.  Тайлант хугацаанд тус газарт хандан ирүүлсэн нийт өргөдөл гомдол – 424, Үүнээс Нийслэлийн цахим 11-11 төвөөр – 410, 1800-1200 дугаарын оператор 10, E-Service 3, Дижитал сити 1 тус тус өргөдөл гоидол ирсэн байна.  2024 оны хагас жилийн байдлаар тус газарт цахимаар хандан ирүүлсэн Нийт албан бичгүүд– 359 албан бичгийг шийдвэрлэн ажиллаж байна.	100%	
1.3.	<b>№109</b>	Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай  <b>2024-10-02</b>	Засгийн газрын 2024 оны 109 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээ"-г албан хаагчад танилцуулж, газрын албан хаагчдын цахим сүлжээнд байршуулсан.	100%	
Хэсгийн дундаж: хувь					
<b>2. Монгол Улсын Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал</b>					
2.1.	<b>№А/44 А-40</b>	Маягтын загвар, аргачлал батлах тухай (хамтарсан тушаал) <b>2024.03.06</b>	Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын загварын хавсралт НД-7, НД-8 маягтын дагуу аж олгогч шимтгэл төлөлтийн тайланг сар бүрийн 5-ны өдрийн дотор ирүүлж байгаа. 2024 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар нийт 4158 аж олгогчын шимтгэл төлөлтийн тайланг баталгаажуулсан байна.	100%	
2.2	<b>№ А/80</b>	Мэргэшлийн зэрэг олгох тухай	Нийгмийн даатгалын улсын байцаагчийн “Тэргүүлэх” мэргэшлийн зэргийн болзол хангасан 6, “Зөвлөх” мэргэшлийн зэргийн болзол хангасан 11 албан хаагчдад журамд заасны дагуу үндсэн цалингийн хувиар тооцож мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгосон.	100%	

		<b>2024-04-18</b>			
2.3	<b>№А/39</b>	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны удирдамж зардлын жишиг хэмжээг батлах тухай  <b>2024-02-28</b>	Хөдөлмөр эрхлэлтийн үйл ажиллагааг төрийн байгууллагуудын зүгээс зорилтот бүлгийн иргэдэд нэгдсэн удирдлага, арга зүй, зохион байгуулалттайгаар хүргэж, хэрэгжилтийг ханган ажиллах ажлын хүрээнд: Ажил олгогчийн санхүүгийн дэмжлэг авахаар гэрээ байгуулсан ажил олгогч нарт шаардлагатай тодорхойлолт (ажил олгогчийн нийгмийн даатгал төлсөн тодорхойлолт)-г гаргаж өгсөн.	100%	
2.4	<b>№А/87</b>	Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай <b>2024-04-23</b>	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2023 оны А/221 дүгээр тушаалаар баталсан “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор, хөдөлмөрийн хортой, халуун, хүнд нөхцөлд хамаарах ажил мэргэжлийн жагсаалт”-д зарим албан тушаалын нөхцөл нэмэгдсэнийг тухай бүр байцаагч ажилтнуудад танилцуулж, хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%	
2.5	<b>№А/29</b>	Журамд өөрчлөлт оруулах тухай <b>2024-10-08</b>	Нийгмийн даатгалын улсын байцаагчийн “Тэргүүлэх” мэргэшлийн зэргийн болзол хангасан 5, “Зөвлөх” мэргэшлийн зэргийн болзол хангасан 11 албан хаагчдад өөрчлөлт орсон журамд заасны дагуу үндсэн цалингийн хувиар тооцож мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгосон.	100%	
Хэсгийн дундаж: хувь					
<b>3. Монгол Улсын Сангийн сайдын тушаал</b>					
3.1.	<b>№А/44 А/40</b>	Маягтын загвар, аргачлал батлах тухай  (хамтарсан тушаал) <b>2024.03.06</b>	Нийгмийн даатгалын болон НДСОТТХууль, ЦАХТТХуулийн дагуу өндөр насны 1660, Хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэвэр 557, тэжээгчээ алдсаны тэтгэвэр 116, Тэтгэврийн тусгай зохицуулалт 199 нийт 2532 тэтгэврийн материалыг хүлээн авч тогтоон тэтгэвэр тогтоолтын хуудсыг тухай бүр нь хэвлэн гарын үсэг, тамаг тэмдэгээр баталгаажуулан ажилласан. Мөн тэтгэвэр тогтоолгосноос хойш 1 жил буюу 12 сараас доошгүй хугацаанд ажил хөдөлмөр эрхэлж НДШ төлсөн, 6-7 жилийн дунджийг 5 жилийн дунджаар солих хүсэлт гаргасан 1503 иргэний тэтгэврийг шинэчлэн тогтоож тогтоолтын	100%	

			хуудсыг тухай бүр нь хэвлэн гарын үсэг, тамаг тэмдэгээр баталгаажуулан тэтгэврийн хувийн баяжуулалт хийж ажиллаа. НДСОТТХуулийн дагуу ХЧТА-ны 3621, жирэмсэн амаржсаны 2998, нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж 1384, ҮОМШӨ-ний ХЧТА-ны 45, ҮОМШӨ-ний нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж-6 ажилгүйдлийн 4122, нийт 12176 иргэний тэтгэмжийн материалыг хүлээн авч тогтоолтын хуудсыг хэвлэн баталгаажуулан нягтлан бодох анхан шатны маягтыг тухай бүр нь бүрдүүлж ажиллаж байна.		
Хэсгийн дундаж: хувь					
<b>5. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол</b>					
4.1	<b>№01</b>	Журам батлах тухай <b>2024.03.05</b>	Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 01 дугаар тогтоолоор “ Нэрийн дансыг нээх, бүртгэх, хөтлөх, даатгуулчийн гарааны үлдэгдлийг тооцохтой холбогдсон харилцааг зохицуулах журам”-ыг батласныг холбогдох хэлтсийн албан хаагчид, ажил олгогч байгууллагууд, иргэд даатгуулагчдад мэдээлэл хүргэн ажилласан.	100%	
4.2	<b>№07</b>	“Журам батлах тухай” <b>2022.12.28</b> <b>№07</b>	2024 оны “Журам батлах тухай” 07 дугаар тогтоолоор батласан “Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах байгууллагыг сонгох, арга хэмжээний зардлын төлбөрийг санхүүжүүлэх, хяналт тавих журам”-ын хэрэгжилтийг хангаж, сургалт авах хэрэгцээ бүхий ажил олгогч, байгууллагуудын судлагааг гаргаж, эрх бүхий сургалтын байгууллагыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллана. 2024 онд дээрхи сургалтын зардлын санхүүжилт орж ирээгүй болно.	100%	
Хэсгийн дундаж: хувь					
<b>6. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал</b>					
5.1.	<b>№А/169</b>	Маягтын загвар батлах тухай	Нийгмийн даатгалын шимтгэлийн ер үүсгэсэн ажил олгогчтой ер барагдуулах төлөөр уулзалт хийх, шимтгэлийн ер барагдуулах гэрээ	100%	

		<b>2024.10.03</b>	байгуулах, харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох тухай ажил олгогчид хүргүүлэх Мэдэгдэл, Албан шаардлага зэргийг шат дараалалтай авч хэрэгжүүлж байна.  Албан шаардлага: 281 Мэдэгдэл: 494 Данс хаалт: 1583 Өр барагдуулах гэрээ: 154 Уулзалтын тэмдэглэл: 126 тус тус гүйцэтгэсэн байна.		
5.2.	<b>№А/01</b>	Малчны нөхцлөөр өндөр настан тогтоох тухай <b>2024.02.19</b>	2024 оны байдлаар Малчны нөхцлөөр нийт 14 хүн тэтгэвэр тогтоолгосон байна.	100%	
5.3.	<b>№А/138</b>	Төлөвлөгөө батлах тухай <b>2024.08.05</b>	Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жилийн хүрээнд Сонгинохайрхан дүүргийн хөдөлмөр, халамж үйлчилгээний хэлтэс, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын тамгын газартай хамтран “АЖИЛ ОЛГОГЧДЫН ЗӨВӨЛГӨӨН”-ийг 2024 оны 05 дугаар сарын 16-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Тус сургалтыг Манд.мн, Сонгинохайрхан дүүргийн фейсбүүк пейж хуудсаар дамжуулсан. <a href="https://www.facebook.com/story.php?story_fbid=989112496552487&amp;id=100063612382399&amp;rdid=r5IJ4fcCtQ9csA1w#">https://www.facebook.com/story.php?story_fbid=989112496552487&amp;id=100063612382399&amp;rdid=r5IJ4fcCtQ9csA1w#</a>  Нийгмийн даатгалын багц хуулийн танилцуулга сэдэвт сургалтыг “ОСНААУГ Баруун түгээх төв”-ийн 66 албан хаагчдад 2024 оны 05 дугаар сарын 14-ны өдөр мэдээлэл, сургалт зохион байгуулж ажилчдад сайн дурын даатгал болон тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой сонирхсон асуултад хариулан ажилласан. <a href="https://www.facebook.com/permalink.php?story_fbid=pfbid0XTqRxq5fJhVJVyZsi8K28UYn5yGKVruQgpBHKZCUiEh4cnqoL1a9AbotQbaJaKvdl&amp;id=100063612382399">https://www.facebook.com/permalink.php?story_fbid=pfbid0XTqRxq5fJhVJVyZsi8K28UYn5yGKVruQgpBHKZCUiEh4cnqoL1a9AbotQbaJaKvdl&amp;id=100063612382399</a>  Хамралтыг нэмэгдүүлэх жилийн хүрээнд “Баатарван Транс” ХХК-ий нийт 190 даатгуулагчдад “Нийгмийн даатгалын хууль тогтоомж”-ийг сурталчлан сургалт зохион байгуулсан. 2024 оны 09 сарын 13-17-ны өдрийн хооронд Сонгинохайрхан дүүргийн 15, 16, 17 дугаар хороонд үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгж байгууллага,	100%	

			<p>хувиараа бизнес эрхлэгчдэд (эмийн сан, шүдний эмнэлэг, хүнсний дэлгүүр, ломбард гэх мэт) нийгмийн даатгалын багц хуулийн хэрэгжилттэй холбоотой хууль тогтоомжын талаарх мэдээллийг хүргэн, хэрэгцээтэй асуултад мэдээлэл өгч, нийгмийн даатгалын 5 сангийн танилцуулга 300 гарын авлага /боршур/-ыг тараан ажиллалаа.</p> <p><a href="https://www.facebook.com/permalink.php?story_fbid=pfbid0275ZdjpiyehPvUTbLY2XBbyKoLQojrDXnn493vrP199LcHAcDRzvTNtb4a4SE81rml&amp;id=100063612382399&amp;rdid=SmKOSlyLYUfqa3G">https://www.facebook.com/permalink.php?story_fbid=pfbid0275ZdjpiyehPvUTbLY2XBbyKoLQojrDXnn493vrP199LcHAcDRzvTNtb4a4SE81rml&amp;id=100063612382399&amp;rdid=SmKOSlyLYUfqa3G</a></p> <p><a href="https://www.facebook.com/permalink.php?story_fbid=pfbid0275ZdjpiyehPvUTbLY2XBbyKoLQojrDXnn493vrP199LcHAcDRzvTNtb4a4SE81rml&amp;id=100063612382399&amp;rdid=zIHe54nfpnma5rHA#">https://www.facebook.com/permalink.php?story_fbid=pfbid0275ZdjpiyehPvUTbLY2XBbyKoLQojrDXnn493vrP199LcHAcDRzvTNtb4a4SE81rml&amp;id=100063612382399&amp;rdid=zIHe54nfpnma5rHA#</a> 2024 оны 09 сарын 18-ны өдөр Сонгинохайрхан дүүргийн 16 дугаар хороонд үйл ажиллагаа явуулж байгаа нийт 38 байгууллагын удирдах албан тушаалтнуудтай уулзан сургалт зохион байгуулсан ба 85 гарын авлага /боршур/-ыг тараан ажиллалаа.</p> <p><a href="https://www.facebook.com/share/p/1ApQ9RkfWM/">https://www.facebook.com/share/p/1ApQ9RkfWM/</a></p> <p>2024 оны 10 сарын 15-ны өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах төв”-ийн 25 албан хаагч, ажилчдад нийгмийн даатгалын хууль тогтоомж, сайн дурын даатгалын төрөл болох хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч буй эцэг эх, асран хамгаалагчдад үзүүлэх хөнгөлөлтийн талаар мэдээлэл хүргэн ажилласан. Нийгмийн даатгалын 5 сангийн танилцуулга 130 гарын авлага тараан ажиллалаа.</p> <p><a href="https://www.facebook.com/share/p/1EkHSvBzvm/">https://www.facebook.com/share/p/1EkHSvBzvm/</a></p> <p>2024.10.04 Хунт Угалз сайхан ХХК-нд НДЭХуулийн шинэчилэлт, хэрэгжилтийн талаар 32 даатгуулагчид зөвлөгөө, мэдээлэл өгсөн.</p> <p>2024 оны 11 сарын 09 өдөр Сонгинохайрхан дүүргийн 101 цэцэрлэгт 20 даатгуулагчдад Сайн дурын даатгал болон нийгмийн даатгалын шинэчлэгдсэн хуулийг сурталчилж сургалтыг зохион байгуулсан. Хамрагдсан даатгуулагч 25.</p> <p><a href="https://www.facebook.com/share/p/1UZvr5bSEs/">https://www.facebook.com/share/p/1UZvr5bSEs/</a></p> <p>“Нээлттэй мэдээллийн сар” аяны хүрээнд худалдаа үйлчилгээний газар болох Сутайн буянт зах, 22 Авто худалдааны төв гэсэн 2 цэгт төвлөрч нийгмийн даатгалын хууль тогтоомжийг сурталчилж, нийгмийн даатгалын үйлчилгээ,</p>		
--	--	--	--	--	--

			<p>шимтгэл төлөлттэй холбоотой асуудлаар иргэдэд заавар зөвлөгөө мэдээллээр ханган ажиллалаа.</p> <p>Тус өдөрлөгт сайн дурын даатгалын талаар 153 иргэнд мэдээлэл хүргэн ажилласан. Үүнээс сайн дурын даатгалын гэрээ шинээр байгуулсан 9, гэрээ сунгасан 23, цахим үйлчилгээ авсан 62, сайн дурын даатгалын талаар зөвлөгөө мэдээлэл 59 иргэнд хүргэн 2313 гарын авлага тараан ажиллалаа.</p> <p>Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 20.1-дэх заалтыг сурталчилах зорилгоор Сонгинохайрхан дүүргийн Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн Улсын бүртгэгч нарт шинэчлэгдсэн хуулийг танилцуулж, гарын авлага /боршур/ материалыг байршуулсан. 2024 онд Улсын бүртгэлд шинээр бүртгүүлсэн аж ахуй нэгж байгууллагууд нийгмийн даатгалын шимтгэл төлөгчөөр шинээр бүртгэл үүсгэж байна.</p>		
5.4.	<b>№А/107</b>	<p>Журам батлах тухай</p> <p><b>2024.06.18</b></p>	<p>Илүү төлсөн шимтгэлийг буцаан олгох журмын дагуу 2 ба түүнээс дээш байгууллагад давхар ажиллаж, төлсөн нийгмийн даатгалын шимтгэл нь төлбөл зохих хэмжээнээс хэтэрсэн, мөн тус дүүрэгт бүртгэлтэй сайн дурын даатгуулагчийн сайн дурын даатгал нь албан журмын даатгалтай давхардсан болон нийгмийн даатгалын шимтгэлээ илүү тооцож төлсөн зэрэг хүсэлтүүдийг өргөдөл бол бусад шаардлагатай баримтыг үндэслэн журамд заасан хугацаанд шийдвэрлэн ажиллаж байна.</p>	100%	
5.5.	<b>№А/43</b>	<p>Даатгуулагчийн төрлийн код нэмж батлах тухай</p> <p><b>2024.04.20</b></p>	<p>Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх нэмж баталсан даатгуулагчийн төрлийн кодуудыг талаар ажил олгогч нарт мэдээлэл хүргэн, мөрдөж ажилласан.</p>	100%	
5.6.	<b>№А/108</b>	<p>Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай</p> <p><b>2024.06.19</b></p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/108 дугаар тушаалын 1.4 дахь заалтын дагуу тус газрын албан хаагчдын дунд Сонгинохайрхан дүүргийн прокурорын газраас Ахлах прокурор Н.Мөнхбат, Хяналтын прокурор Д.Дэлгэрсүрэн, Ж.Отгончимэг нар зөрчил хянан шийдвэрлэх эрх бүхий 9 албан хаагчдад зөрчлийн тухай хууль, зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, хувь хүний нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн талаар сургалт оруулсан.</p>	100%	

			<p>Мөн Авлигатай тэмцэх газарт хүсэлт гаргасны дагуу Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан, комиссар Б.Сүрэнжаваас тус газрын албан хаагчдад зориулж Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.10 заалт, мөн “Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт орж, сургалтаар төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, байгууллага болон хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байх тухай мэдээлэл сургалтыг авлаа.</p> <p>Уг тушаалын 1.7-д заасан асуудлаар мэдээ мэдээлэл задруулсан албан тушаалтны талаар хууль хяналтын байгууллагаас албан ёсны шийдвэр ирээгүй тул шийдвэрлэх боломжгүй байгаа болно.</p>		
5.7.	<b>№А/105</b>	Төлөвлөгөө батлах тухай <b>2024.06.13</b>	Тус газрын 2024 оны Авлигын эсрэг үйл ажиллагааны 4 зорилт 7 арга хэмжээ бүхий төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийн тайланг нотлох баримтыг хавсарган хугацаанд нь НДЕГ-ын Захиргаа, удирдлагын газарт хүргүүлж ажиллав.	100%	
5.8.	<b>№А/61</b>	2024 оны Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгох тухай <b>2024.04.24</b>	<p>2024 оны 11 сарын 30-ны байдлаар 572 аж ахуйн нэгж байгууллагын албан хүсэлтийг хүлээн авч, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогчоор бүртгэн 3190 даатгуулагчийг шинээр хамруулсан. Сайн дурын даатгалд 4854 даатгуулагч шинээр хамрагдаад байна. Үүнээс:</p> <ul style="list-style-type: none"> <li>✓ 0-3 нас хүртгэлх хүүхэдтэй эх 484,</li> <li>✓ Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг эх 265,</li> <li>✓ Малчин 29 даатгуулагч хамруулсан байна.</li> </ul> <p>Ажил олгогч, албан журмын даатгуулагч, сайн дураар даатгуулагчийн тооны төлөвлөгөө 100%-иар биелүүлсэн.</p>	100%	
5.9.	<b>№А/64</b>	Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах сангийн ажлыг	Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах чиглэлээр 2024 онд хийх ажлын төлөвлөгөө гарган ажиллаж сангийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэх, нийгмийн даатгалд хамрагдаагүй ажил олгогч, иргэнийг нийгмийн даатгалд бүрэн хамруулах, нийгмийн даатгалын шимтгэл төлөгч ажил олгогч, даатгуулагчдын нийгмийн даатгалын шимтгэлийг хуулийн хугацаанд төлүүлэх, өр авлага барагдуулах ажлуудыг зохион байгуулан ажилласны үр дүнд 2024	100%	



		эрчимжүүлэх тухай <b>2024.05.02</b>	оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар нийгмийн даатгалын санд 239 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлэхээс 224 тэрбум төвлөрүүлж, төлөвлөгөөг 93,7%-иар биелүүлсэн. 2023 оны жилийн эцсийн шимтгэл өр 34,2 тэрбум төгрөгөөс 2024 оны 11-р сарын 30-ны өдрийн байдлаар 22,8 тэрбум төгрөгийг 66,8%-иар барагдуулсан		
5.10	<b>№А/162</b>	Аян зохион байгуулах тухай <b>2024.09.26</b>	<p>90 хүртэл хоногийн насжилттай өр үүсгэсэн аж ахуй нэгжид өр барагдуулах талаар сануулах, албан шаардлага хүргүүлэх:</p> <p>38,8 тэрбум төгрөгийн өртэй 507 байгууллагад мэдэгдэх хуудас, 13,8 тэрбум төгрөг бүхий 265 байгууллагад албан шаардлага хүргүүлж 5,3 тэрбум төгрөгийг барагдуулсан.</p> <p>90 хүртэл хоногийн насжилттай 1762 байгууллагын 24,9 тэрбум төгрөгөөс 19,6 тэрбум төгрөгийг авлагыг барагдуулсан.</p> <p>91-270 хоногийн насжилттай аж ахуй нэгж байгууллагын удирдлагатай холбогдох, уулзалт зохион байгуулах, гэрээ тэмдэглэл үйлдэн баталгаажуулах, харилцагч банканд мэдэгдэл хүргүүлж, үл маргах журмаар данснаас гаргуулах:</p> <p>Аяны хугацаанд 154 байгууллагын 27,9 тэрбум төгрөгийн аж ахуй нэгжтэй график байгуулсан. 125 байгууллагын 7,1 тэрбум төгрөгийн аж ахуй нэгжтэй уулзалт хийж нийт 13,5 тэрбум төгрөгийг барагдуулсан.</p> <p>1583 байгууллагын 12,7 тэрбум төгрөгийн дансны гүйлгээг зогсоож үл маргах журмаар 180 байгууллагын 2,8 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулсан.</p> <p>Нийт 683 байгууллагын 12,4 тэрбум төгрөгийн авлагаас 8,1 тэрбум төгрөгийг барагдуулж ажилласан.</p> <p>271 хоногоос 3 жилийн насжилттай өр үүсгэсэн аж ахуй нэгж, байгууллагын баримт бичгийн бүрдүүлбэрийг ханган, хуулийн байгууллагад шилжүүлэх:</p> <p>Аяны хүрээнд 16 байгууллагын 894 сая төгрөгийн аж ахуй нэгж байгууллагын баримт бичгийн бүрдүүлэлтийг ханган 10 аж ахуй нэгжийн 572,8 сая төгрөгийн</p>	100%	

			<p>өртэй байгууллагыг шүүхэд нэхэмжлэл гаргаж өгсөн. / хурлын зар тавигдахыг хүлээж байна/</p> <p>Нийт 271 хоногоос 3 жилийн насжилттай 793 байгууллагын 10,8 тэрбум төгрөгөөс 4,4 тэрбум төгрөгийг барагдуулсан.</p> <p>3 ба түүнээс дээш жилийн насжилттай үйл ажиллагаа нь зогссон, мөн оршин байгаа хаяг тодорхойгүй, хариуцах эзэн холбогдогч нь сураггүй болсон, нас барсан, хуулийн этгээд татан буугдсан болон дампуурсан зэрэг аж ахуйн нэгж байгууллагыг эрэн сурвалжлах ажлыг зохион байгуулан, дараагийн шатны байгууллагад хандаж шийдвэрлүүлэх, ажил олгогчийн хувийн хэрэгт нотлох баримтыг хавсарган баримт бичгийн бүрдүүлбэрийг хангах:</p> <p>Хаяг тодорхойгүй эзэн холбогдогч сураггүй алга болсон гадаад эзэнтэй байгууллагуудын судалгааг гарган ажиллаж байна.</p> <p>Аяны хугацаанд 408 байгууллагын 156,9 сая төгрөгийг барагдуулсан.</p>		
5.11.	<b>№А/34</b>	Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай <b>2024.03.18</b>	Тус байгууллагын үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/34 дугаар тушаалын дагуу батлагдсан төсвийн хуваарийг баримтлан зарцуулалтад хяналт тавин ажиллаж байна.	100%	
5.13.	<b>№А/35</b>	Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай <b>2022.03.18</b>	Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалын дагуу батлагдсан төсвийн хуваарийг баримтлан ажиллаж байна. Мөн энэ тушаалын хавсралтад заасан ажил олгогч, даатгуулагч, олон нийтэд чиглэсэн сурталчилгаа, зөвлөн туслах үйлчилгээний зардлын сарын хуваарийн задаргааг ирүүлснийг мөн хэрэгжүүлж ажиллаж байна.	100%	

5.14.	<b>№А/80</b>	Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай <b>2024.05.21</b>	Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/80 дугаар тушаалаар тус газрын нийгмийн даатгалын холбогдох сангийн зарлагын төсвийн хуваарийг урагшлуулсан тул батлагдсан төсвийн хуваарийг баримтлан ажилласан.	100%	
5.15.	<b>№А/83</b>	Маягтын загвар батлах тухай <b>2024.05.21</b>	Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй байгууллагад баталсан маягтын дагуу авсан арга хэмжээ:  38,8 тэрбум төгрөгийн өртэй 507 байгууллагад мэдэгдэх хуудас, 13,8 тэрбум төгрөг бүхий 265 байгууллагад албан шаардлага хүргүүлж 5,3 тэрбум төгрөгийг барагдуулсан. 1583 байгууллагын 12,7 тэрбум төгрөгийн дансны гүйлгээг зогсоож үл маргах журмаар 180 байгууллагын 2,8 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулсан.	100%	
5.16.	<b>№А/94</b>	Аудитын акт, албан шаардлага зөвлөмж хэрэгжүүлэх тухай <b>2024.05.31</b>	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн А/94 дугаар “Аудитын акт, албан шаардлага зөвлөмж хэрэгжүүлэх тухай” тушаалын биелэлтийг хангаж ажилласан. Тус газар нь 2023 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 5 зөвлөмжийн биелэлтийг хангах газрын даргаар батлуулсан ажлын төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөний дагуу ажиллаж, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримтын хамт Нийслэл дэх Төрийн аудитын газарт хүргүүлсэн. Цаашид зөвлөмжөөр өгөгдсөн зөрчлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллаж байна.	100%	
5.17.	<b>№А/124</b>	Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай <b>2024.07.09</b>	Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 09-ний өдрийн “Тушаалд нэмэлт өөрчлөлт оруулах тухай” А/124 дугаар тушаалаар 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс нийгмийн даатгалын байгууллага нь улсын төсвөөс санхүүждэг болсонтой холбоотой нийгмийн даатгалын байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт зарим дансны бичилт өөрчлөлт орсныг нягтлан бодох бүртгэлд хэрэгжүүлж ажиллаж байна.	100%	

5.18.	<b>№А/129</b>	<p>Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай</p> <hr/> <p><b>2024.07.16</b></p>	<p>Тус байгууллагын үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн А/129 дугаар тушаалаар байгууллагаас хүргүүлсэн саналыг үндэслэн урсгал зардлын төсвийг ангилал хооронд шилжүүлэх, зарим зардлын сарын хуваарьт өөрчлөлт оруулсныг хэрэгжүүлж ажиллаж байна.</p>	100%	
5.19	<b>№А/179</b>	<p>Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай</p> <hr/> <p><b>2024-10-22</b></p>	<p>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 10 дугаар сарын 22-ний өдрийн А/179 дугаар Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай тушаалаар зарим даатгалын сангийн зардлын төсөвт өөрчлөлт орсон тул батлагдсан зардлын төсвийн хуваарийг баримтлан зарцуулалтад хяналт тавьж ажилласан.</p>	100%	
5.20	<b>№А/67</b>	<p>Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай</p> <hr/> <p><b>2024-05-07</b></p>	<p>Тус байгууллагын үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарийг шинэчлэн батлах тухай Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/67 дугаар тушаалаар байгууллагаас хүргүүлсэн саналыг үндэслэн урсгал зардлын төсвийг ангилал хооронд шилжүүлэх, зарим зардлын сарын хуваарьт өөрчлөлт оруулсныг хэрэгжүүлж ажиллаж байна.</p>	100%	

Хэсгийн дундаж: 100хувь

Нийт дундаж: 100хувь